



65

Б Н М А У
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 10 сарын 31

№ 810.

Улаанбаатар хот

Хотын аюулгүйн сан байгуулах тухай

БНМАУ-ын Засгийн газрын 1990 оны 152 дугаар тогтоолыг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Байгалийн гамшиг үйлдвэрийн томоохон осол, гоц аюулт халдварт өвчин, ой, хээрийн түймэр, цацраг идэвхт болон хүчтэй үйлчилгээтэй хорт бодисын аюул, нөлөөнөөс урьдчилан сэргийлж хамгаалах, хор уршгийг арилгах ажилд зориулж зарцуулах Хотын аюулгүйн санг 2,0 сая төгрөгөөр баталсугай.

2. Байнгын онцгой комисс, түүний ажлын аппаратад шаардагдах албан томилолтын болон унаалгын зардал, урьдчилан сэргийлэх, гамшиг ослын хор уршгийг арилгахад татан оролцуулах бие бурэлдэхүүнийг сурган дадлагажуулахад батлагдсан зардлын 10 хуртэл хувийг зарцуулан тооцож байхыг Хотын байнгын онцгой комиссын орлогч дарга /Л.Доржсүрэн/-д зөвшөөрсүгэй.

3. Байнгын онцгой комисс, түүний ажлын аппаратад шаардагдах албан томилолтын болон унаалгын зардал, урьдчилан сэргийлэх, гамшиг ослын хор уршгийг арилгахад татах оролцуулах бие бурэлдэхүүнийг сургаж дадлагажуулахад зориулж батлагдсан зардлыг ашиглах зааварчилга гаргаж батлуулахыг Хотын онцгой комиссын орлогч дарга /Л.Доржсүрэн/-д даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАРГА

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАИХАН